

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

“МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

“МЕРЕКС” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал “БАЯНГОЛ” зочид буудлын хурлын танхимд 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цант эхэлж нийт 2 цаг үргэлжлэн 12:00 цагт өндөрлөв.

Б. Эрдэнэжаргал: Мерекс ХК-ийн саналын эрх бүхий нийт 65,005,000 ширхэг хувьцаанаас өнөөдрийн хуралд 46,792,175 ширхэг хувьцаа буюу 71,98 хувьтайгаар хувьцаа эзэмшигчид хуралд өөрийн биеэр болон эчнээ санал хураалтаар оролцож байгаа учраас энэ хурлыг хүчин төгөлдөр гэж тооцож болно.

Н. Улаанхүү: Хурлын ирц бүрдсэн тул хурлаа эхлэе. Эрхэм хүндэт Мерекс ХК”ийн хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж, Хувьцаа эзэмшигчийн хурал нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хурал дараах дарааллын дагуу явагдана.

- ✓ Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах
- ✓ Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах
- ✓ Асуулт хариулт
- ✓ Хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалт
- ✓ Тооллогын комисс тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлаас гарсан шийдвэр тогтоолыг танилцуулах

Эхлээд Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулъя.

Мерекс ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2018 оны төлөвлөгөөний талаарх илтгэлийг компанийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд тавьж байна.

“Мерекс” ХК-ийн ТУЗ нь компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг мөрдөж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, компанийн үйл ажиллагааг жигдрүүлэн, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллалаа.

2017 онд компанийн нийт хамт олон “Мерекс” ХК-ийн ТУЗ-өөс баталсан 2017 оны төлөвлөгөөний дагуу түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, шинэ санал санаалчлагыг дэмжих, санхүүгийн хямд эх үүсвэрийг олж ашиглахад чиглэгдсэн

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нөөц бололцоогоо дайчлан ажилласан.

Үүний үр дүнд 2017 онд дэлхийн эдийн засаг болон Монгол улсын эдийн засагт тулгарсан хямралаас шалтгаалан Барилгын салбарын хувьд хүндхэн жил байсан хэдий ч “Мерекс” компанийн хувьд үйлдвэрлэлээ амжилттай үргэлжлүүлж зах зээлд өөрийн орон зайг бий болгож, харилцагч байгууллагуудынхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж ажилласан жил байлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3-р сарын 19-ны өдрийн хурлаар компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэн, бизнес төлөвлөгөөний ерөнхий биелэлтийг үзүүлэлт бүрээр хангалттай гэж үзэн, энэхүү дүгнэлтийг Компанийн тухай хууль болон Дүрмийн дагуу компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар тогтсон байна.

Мерекс ХК ны дээрх дүгнэлтэнд дурьдсанаар өнгөрсөн онд энэ салбарын хувьд хүндрэлтэй жил байсан хэдий ч үйлдвэрлэлээ хэвийн явуулж мөн энэ жилийн үйл ажиллагаагаа эхлүүлэх шаардлагатай түүхий эдийн бэлтгэлийг хангасан болно.

Одоо компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг тус компанийн Гүйцэтгэх захирал М. Мөнхзолбоо танилцуулна.

М. Мөнхзолбоо: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Манай компани нь 2012 онд Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдаад 2014 оны 8-р сард үйлдвэрээ бүрэн угсарч дуусаад 2015 оноос бетон зуурмагийн үйлдвэрлэлээ албан ёсоор эхлүүлсэн. Үйлдвэрлэлийн хувьд төлөвлөгөө 40,000м³ бетон зуурмаг үйлдвэрлэх байсан боловч энэ жил барилгын салбар хямралтай байснаас төлөвлөгөөндөө хараахан хүрэлгүй 14825м³ бетон зуурмаг үйлдвэрлэж, нийт 2.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Санхүүгийн ашигтай ажиллагааны хувьд 2.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 65.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Өнгөрсөн онд 136,000 хувьцаа арилжигдаж үнийн дүн 4,080,000 төгрөг болсон байна.

Н. Улаанхүү: Өнгөрсөн онд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2017 оны 4-р сарын 30-ны өдөр хуралдуулсан. Хурлын ирц 84,7 хувьтай байж, хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах.
2. Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах.
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
4. ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв батлах.
5. Ногдол ашиг тараах эсэх.

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

“Мерекс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл тайлант 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, компанийн үйлдвэрлэл, удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудлаар зайлшгүй шийдвэл зохих асуудлуудыг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргаж, хяналт тавьж ажилласан.

Өнгөрсөн онд ТУЗ-ийн хурлыг биет болон цахим хэлбэрээр хийсэн. Гишүүдийн биечлэн оролцсон 3 удаа хийж 10 асуудлыг шийдвэрлэсэн. Зарим яаралтай асуудлыг шийдвэрлэхийн тулд хурлыг цахим хэлбэрээр 2 удаа хийж тодорхой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ангилан үзвэл:

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд: Компанийн бизнес төлөвлөгөө, их хэмжээний хэлцэл болон борлуулалтын төлбөрт шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан борлуулах зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 5 удаа
2. Санхүү, аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд: Хараат бус аудитын байгууллага сонгох зэрэг санхүү, аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 3 удаа
3. Компанийн удирдлага, зохион байгуулалт: Компанийн ТУЗ-ийн дарга гишүүдийг сонгох, Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах, удирдах ажилтны гүйцэтгэлийн хариуцлага зэрэг удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудлаар 1 удаа
4. ТУЗ-өөс өгсөн даалгавар, чиглэл: ТУЗ-өөс өгсөн даалгавар, чиглэл, төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудлаар 2 удаа тус тус хуралдсан байна.

Компани нь нийгмийн хариуцлага, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үйлдвэрийн байгаа орчин өөрөө тоосжилт ихтэй байдаг учир энэ чиглэлээр зайлшгүй анхаарах хэрэгтэй байдаг.

Өнгөрсөн оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг нэгтгэн та бүхэнд хүргэлээ.

Одоо 2018 оны төлөвлөгөөг танилцуулъя.

Энэ онд компани нь 40,000 м³ бетон зуурмаг үйлдвэрлэж, нийт 4.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж байна.

Төлөвлөгөөт борлуулалт хийснээр 203,5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж ногдол ашгийн бодлогын хүрээнд цэвэр ашгийн 25%-иас багагүй хэмжээний ногдол ашиг хуваарилаар тооцоолж байна. Үүнийг компанийн удирдлага болон компанийн ажилтан нар биелүүлэн ажиллана гэдэгт найдаж байна.

Дараагийн танилцуулах асуудал бол хараат бус аудитын тайлан.

Бид компанийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргах компанийг сонгохдоо үйлчилгээний үнэ, ажлын туршлага, тухайн компани нь Хувьцаат компанид аудит хийх зөвшөөрөлтэй эсэх гэсэн үндсэн 3 зүйлийг шалгуур үзүүлэлт болгосны

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

дагуу хорооны гишүүдийн саналыг үндэслэн компанийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргах компаниар “Нийслэл аудит” ХХК-г сонгосон.

Ингээд хараат бус аудитын дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Нийслэл аудит” ХХК нь “Мерекс” ХК-ийн 2017 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлсэн байна гэж дүгнэж байна гэсэн байна.

Санхүүгийн тайланг та бүхэн хурлын материалын танилцуулгаас харах боломжтой.

Энэ тайлангаар 2016 онд нийт активын дүн 4.9 тэрбум байсан бол 2017 оны 12-р сарын 31-ний байдлаар 4,4 тэрбум болсон үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлогын хувьд 2016 онд 4.2 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 2.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.

Борлуулалтын нийт өртөг нь 1.9 тэрбум төгрөг, үйл ажиллагааны нийт ашиг нь 430,8 сая төгрөг, үүнээс холбогдох зардлыг хассан татварын өмнөх болон дараах дүнгээр 65,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Одоо Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд гэр дэвшиж байгаа хүмүүсээ танилцуулъя.

Эхлээд ердийн гишүүнд нэр дэвшигчдээ танилцуулъя. Үүнд

- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Б. Хуяг. Иргэний харьяалал Монгол улс, 1979 онд төрсөн, Англи хэл, Америк судлаач мэргэжилтэй. Одоо “Стандарт Проперти групп” ХК-ийн Дэд захиралаар ажиллаж байна. 2008-2013 онд “Хера Экуйпмент” ХХК-д Худалдааны хэлтсийн ахлах ажилтан.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч М. Мөнхзолбоо. Иргэний харьяалал Монгол улс, 1979 онд төрсөн. Олон улсын харилцааны мэргэжилтэй. Одоо “Мерекс” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. 2005-2008 онд “Туризм, Хөндлөнгийн хяналт” ХХК-д Ахлах менежер, 2009-2011 онд “Актив хийц” ХХК-д Гадаад харилцааны ахлах менежерийн ажил хийж байсан туршлагатай.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Н. Улаанхүү. Иргэний харьяалал Монгол улс, 1982 онд төрсөн. Эдийн засагч мэргэжилтэй. Одоо “Стандарт Финаншл Групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2005-2006 онд Дэлхийн банк, Тогтвортой амьжиргаа төсөл-д Судалгааны мэргэжилтэн, 2007-2009 онд Анод банк-д эрсдлийн шинжээч, 2010-2014 онд Монет Капитал ҮЦК, Хөрөнгө оруулалтын банкны Хэлтсийн ахлахын ажил хийж байсан туршлагатай.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Д. Баттулга. Иргэний харьяалал Монгол улс, 1982 онд төрсөн. Санхүү удирдлагын мэргэжилтэй. Одоо “Стандарт Финанс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2005-2009 онд “Зоос банк” 110-р салбарын Зээлийн эдийн засагч, 2010-2012 онд “Апу трейдинг” ХХК-д Дотоод аудитор, 2010.02-2010.06 онд “Нүүрсний зам” ХХК-д Ерөнхий нябоггор ажиллаж байсан туршлагатай.

- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч М. Ундрал. Иргэний харъяалал Монгол улс, 1977 онд төрсөн, Менежер мэргэжилтэй. Одоо хувиараа бизнес эрхэлж байна. 2000-2011 онд “Нийтийн тээврийн зохицуулах газар”-т Санхүүгийн хэлтсийн ажилтан, 2003-2006 онд “Ти-Эс Эйч Трейд” ХХК-д Менежер, “Түгээмэл Трейд” ХХК-д Менежерийн ажил хийж байсан туршлагатай.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Ч. Жаргал. Иргэний харъяалал Монгол улс, 1975 онд төрсөн, Санхүүч мэргэжилтэй. Одоо “Стандарт Инвестмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2002-2003 онд “Монголын нээлттэй нийгэмлэгийн хүрээлэн”-д Иргэний нийгмийн хөтөлбөрийн Төслийн зохицуулагч, 2003-2009 онд “Их Британийн Хүүхдийг Ивээх сан”-ийн Төслийн ажилтан, Хөтөлбөрийн менежерээр ажиллаж байсан туршлагатай.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчдээ танилцуулъя.

- ✓ Хараат бус гишүүнд нэр дэвшигч Н. Ичинхорлоо. Иргэний харъяалал Монгол улс, 1953 онд төрсөн, Хуульч мэргэжилтэй. Одоо өмгөөллийн “Монгол зарга” Нөхөрлөл-ийн Захиралаар ажиллаж байна. 1992-1994 онд “Хууль зүйн яам”-нд Мэргэжилтэн, 1994 онд Архангай аймгийн сум дундын Ерөнхий шүүгч, 2001-2007 онд Баянгол дүүргийн шүүхийн Ерөнхий Шүүгч, 2007-2011 онд Хан-Уул дүүргийн шүүхийн Шүүгчээр ажиллаж байсан туршлагатай.
- ✓ Хараат бус гишүүнд нэр дэвшигч Н. Өлзийхишиг. Иргэний харъяалал Монгол улс, 1978 онд төрсөн, Программист мэргэжилтэй. Одоо “Чингис хаан банк”-нд Ахлах программистаар ажиллаж байна. 2000-2001 онд “Эрдэнэт УБҮ”-д Инженер-программист, 2001-2007 онд “Анод банк”-нд Программист, ахлах программистийн ажил хийж байсан туршлагатай.
- ✓ Хараат бус гишүүнд нэр дэвшигч П. Дагвасүрэн. Иргэний харъяалал Монгол улс, 1980 онд төрсөн, Олон улсын харилцааны мэргэжилтэй. Одоо “Бианконеро Констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2004 онд МУИС-ийн Англи хэлний багш, 2004-2007 онд УИХ-ын Тамгын газарт УИХ-ын гишүүний туслах, 2007-2008 онд “Жи Мобайл” ХХК-д Борлуулалтын менежер, 2008-2010 онд “Баянхонгор Трейд Центр” ХХК-ийн Орлогч захирал, 2008-2014 онд “Баянхонгор Констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан туршлагатай.

Компанийн үйл ажиллагаанд олон талаас нь дүгнэлт өгч ажиллах үүднээс олон талын мэргэжилтэй хүмүүсийг компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлсэн.

Ерөнхийдөө танилцуулах асуудлууд дуусаж байна. 2018 оны 03-р сарын 19-ний ТУЗ-ийн хурлаар компани хэдийгээр ашигтай ажилласан ч ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдсэн. Ногдол ашиг хуваарилахгүй шийдвэрийг дараах байдлаар тайлбарлаж байна.

1-рт, 2017 оны ашгийг эргэлтийн хөрөнгийн чадавхиа сайжруулах чиглэлээр зарцуулахаар шийдсэн.

2-рт, Компанийн тухай хуулийн 47.1.2-т зааснаар хуримтлагдсан алдагдлын дүнгээр нийт эздийн өмчийн дүн буурсан байгаа учраас 47.1.2 дах заалт хангагдаагүй тул энэ жил ногдол ашиг хуваарилах боломжгүй байна.

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

За одоо дээрх танилцуулагдсан асуудлууд болон ТУЗ-д нэр дэвшигчдээс асуух асуулт байвал асууна уу. Тэгээд асуулт хариултын дараа саналын хуудас тарааж өгнө.

Асуулт

Хувьцаа эзэмшигч: Бартерийн байрнуудаас байгаа юу?

М. Мөнхзолбоо: Байгаа. Хувийн шугамаар уу эсвэл зүгээр мэдээлэл авах гэж асууж байна уу? Авлагад орж ирсэн бартерийн байрнуудыг борлуулах тал дээр банкнаас дэмжлэг авч ажиллах бодолтой байна. Мөн түүхий эдийн худалдан авалтандаа бартер хийж гаргадаг.

Хувьцаа эзэмшигч:

- Авлага өглөгийн талаар тодруулъя. Бас энэ жилийн төлөвлөгөөний хувьд юу байна?

М. Мөнхзолбоо: Барилгын зах зээл сүүлийн жилүүдэд хямралтай байгаа. Энэ байдал нь барилгын борлуулалт буурсантай мөн энэ зах зээлд бартерийн борлуулалт өндөр хувийг эзэлж байгаатай холбоотой. Өглөг дээр өнгөрсөн жилийн гүйцэтгэж дуусаагүй байгаа одоо үргэлжилж байгаа ажлуудын барагдуулаагүй төлбөрүүд байгаа юм. Мөн олон газруудтай барилгын ажил эхлүүлэх гэж байна. Хэлэлцээр хийж байгаа 4 гэрээ байгаагаас 2 гэрээ нь гарын үсэг зурах шатанд явж байна. Түүнчлэн 5-р сараас өнгөрсөн жилийн байгуулагдсан гэрээний барилгын ажлууд үргэлжилнэ.

Н. Улаанхүү: Гацалт үүсээд байгаа гол асуудал бол авлага, өглөгийн асуудал байгаа юм. Энэ жил банкнаас ипотекийн зээл дэмжигдэж байгаа учраас бартерийн байрыг борлуулах тал дээр анхаарч ажиллана. Ашиг орлого ч өмнөх жилийнхээс өндөр байх хүлээлттэй байна.

Хувьцаа эзэмшигч:

- Ажлыг нь гүйцэтгэж дуусаагүй байгаа болохоор өглөг, авлаг гүйцээгүй гэсэн үг үү.

М. Мөнхзолбоо: Тийм. Ерөнхийдөө гэрээний дагуу бүх ажил хийгдэж дуусаад өглөгийн асуудал шийдэгдэнэ.

Н. Улаанхүү: Одоо 15 минутын цайны завсарлагын дараа тооллогын комиссын дүнг танилцуулъя.

Н. Улаанхүү: Та бүхэнд өөр асуулт, тодруулах зүйл байна уу.

-Тооллогын дүн гарсан байна. Стандарт Инвестмент ҮЦК-ийн үнэт цаасны диллер Б. Эрдэнэжаргал тооллогын дүнг танилцуулна.

Б. Эрдэнэжаргал: Өнөөдрийн Мерекс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж буй асуудлуудад өөрийн биеэр болон эчнээ санал хураалтаар оролцсон хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг танилцуулъя.

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

- Санал хураалтаар компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг 100 хувийн саналтайгаар баталсан байна.
- Дараагийн хэлэлцсэн асуудал- ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг 100 хувийн саналтайгаар баталсан байна.
- ТУЗ-ийн Ердийн гишүүдэд нэр дэвшиж байгаа Б. Хуяг, М. Мөнхзолбоо, Н.Улаанхүү, Д. Баттулга, М. Ундрал, Ч. Жаргал нар тус бүр 16,67 хувийн санал авсан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа Н. Ичинхорлоо, Н. Өлзийхишиг, П. Дагвасүрэн нар тус бүр 33,33 хувийн санал авсан байна. Ингэснээр эдгээр нэр дэвшигчид нь Мерекс ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдож байна.

Н. Улаанхүү: За ингээд тооллогын дүнг үндэслээд тогтоолын төслүүдийг танилцуулъя.

Тогтоол-1

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Мерекс” ХК-ийн 2018 оны 4-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Тогтоол-2

Та бүхэн хурлын материал дээрээс ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг харсан байх. Нийтдээ 25,1 сая төгрөг төсөвлөгдсөн байгаа.

Компанийн тухай хуулийн 62.1.13 дэх заалт болон Мерекс ХК-ийн 2018 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг хавсралтаар БАТАЛСУГАЙ.

Нэг хуралдаанд оролцохтой холбоотой зардлыг гишүүдэд 300,000 төг, ТУЗ-ийн дарга 400,000 төг, бусад зохион байгуулалт болон томилолттой холбоотой зардлууд нийлээд 25,1 сая төгрөг болж байна.

Энэ жил барилгын салбар хямралтай байгаа учир ТУЗ-ийн гишүүдийн цалин хараахан олгогдоогүй байгаа.

Тогтоол-3

ТУЗ-ийн гишүүдээ сонгох тухай тогтоол

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИ

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, “Мерекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 4-р сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:

Ердийн гишүүдэд:

- Б. Хуяг
- М. Мөнхзолёоо
- Н. Улаанхүү
- Д. Баттулга
- М. Ундрал
- Ч. Жаргал

Хараат бус гишүүдэд:


- Н. Ичинхорлоо
- Н. Өлзийхишиг
- П. Дагвасүрэн нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр СОНГОСУГАЙ.

2. Компанийн үр ашигтай ажиллагааг хууль журмын дагуу удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг БОЛГОСУГАЙ.

-За ийнхүү энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай зохион байгуулагдаж, холбогдох асуудлуудыг танилцуулж, хэлэлцэн, шийдвэрээ гаргалаа. ТА бүхэнд хуралдаа идэвхтэй оролцсонд баярлалаа. Хурал хаагдсаныг үүгээр мэдэгдэж байна.

Хурлын тэмдэглэл бичсэн:  Т. Уянга

ТУЗ-ийн НБД

Хянасан:  Б. Хуяг

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл